

ХАГАС ЖИЛ, УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /МАЯГТ 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2025 оны 1-р сарын 01 - 2025 оны 6-р сарын 30
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	СҮҮ ХК, УБГД: 000219594 ҮЦК: 135-СҮҮ Утас: 7707-2222
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, Үхрийн сүүний ферм, малын тэжээлийн ургамал тариалах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	344.000.000 ширхэг
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрэхжаргал

1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайлан хавсаргав
	Орлогын тайлан	Тайлан хавсаргав
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайлан хавсаргав
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайлан хавсаргав

2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	Хурлаар хэлэлцэж баталгаажуулсан
---	---	----------------------------------

3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт, сайжруулалтанд томоохон хөрөнгө оруулалтууд хийгдсээр байна. Үүнтэй холбоотой бүтээгдэхүүний чанар нэмэгдэх, чанартай шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээл дээр гаргаж хэрэглэгчдэд хүргэснээр үйл ажиллагааны цар хүрээ өсч байна.
---	--	---

3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь: 29.36%
		Цэвэр ашгийн хувь: 5.99%
		Нийт хөрөнгийн өгөөж (ROA): 4.12%
		Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 10.35%
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа: 1.12
		Түргэн хөрвөх чадварын харьцаа: 0.44
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөнд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Чанартай, эрүүл мэндэд ээлтэй сүү, сүүн бүтээгдэхүүнээр нэр төрлийг нэмж зах зээлд гаргасаар байна. Үйлдвэрлэл нэмэгдүүлэх шинэ төсөл хэрэгжүүлэн сүүлийн үеийн шинэ техник, технологиор хүчин чадлыг сайжруулан ажиллаж байна.
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НБББББичгийн дагуу бүртгэсэн.
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон иххэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэйтгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	1. "Сүү" ХК-ийн 2025 оны 02 сарын 26-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №05 тогтоолын дагуу худалдах худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, барьцааны гэрээ, зээлийн гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тээвэрлэлтийн гэрээнүүдийг 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 02 сарын 26-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд холбогдох дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээний хүрээнд "Макс Импекс" ХХК-тай 3,000,000,000 ₮ хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. 2. "Сүү" ХК-ийн 2025 оны 05 сарын 12-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №13 тогтоолын дагуу худалдах худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, барьцааны гэрээ, зээлийн гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, тээвэрлэлтийн гэрээнүүдийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 2026 оны 02 сарын 26-ны өдөр хүртэл 7 сарын хугацаанд "Мөнх ногоон тал" ХХК-тай 1,000,000,000 ₮ хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрсөн.

5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй
---	---	--

6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	Төлөөлөн удирдах зөвлөлтэй бөгөөд 12 гишүүнтэй, "Цалин урамшуулал", "Нэр дэвшүүлэх", "Аудитын", "Эрсдэлийн удирдлага, комплайнс" гэх 4 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна.
---	--	---

7	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	Компанийн шинэчлэгдсэн засаглалын кодекстэй холбоотойгоор шат дараатай ажлуудыг хийж байгаа.
---	---	--

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Гантулга

Албан тушаал: "СҮҮ"-ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)




Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Дэлгэрэхжаргал

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:



20
25



ХАГАС
ЖИЛИЙН
ТАЙЛАН



АЛСЫН ХАРАА

Монгол сүүгээр
дэлхийг ундаална.

ҮНЭТ ЗҮЙЛ

- 67 жилийн туршлага
- Эрүүл хүн
- Аюулгүй ажиллагаа
- Итгэл даасан чанар
- Чадварлаг хамт олон

ЭРХЭМ ЗОРИЛГО

Уламжлан ирсэн сүүн
соёлыг орчин үеийн
хэрэглээнд нийцүүлэн
түгээнэ.

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА »

WWW.SUU.MN




ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын ууган үйлдвэр Сүү ХК нь 1958 онд нийслэлийн хүн амыг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор 30 тонн сүү боловсруулах хүчин чадалтайгаар анх байгуулагдаж байсан түүхтэй.

Эдүгээ бид 800 орчим ажилтан, албан хаагчтай хоногт 130-200 тонн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтайгаар 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн 4,200 цэгт хүрч зах зээлд нийлүүлж байна.

Орчин үеийн сүүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр малчдыг хоршоожуулах хөтөлбөр хэрэгжүүлж, өнөөдрийн байдлаар 32 сүү бэлтгэлийн хоршоо тогтвортой үйл ажиллагаагаа ханган ажиллаж байна.

Мөн бид сүү бэлтгэл нэгдсэн системийг Улаанбаатар хот орчмын 350 км-ийн радиуст байрлах 6 аймаг болох Төв, Дархан, Сэлэнгэ, Орхон, Хэнтий аймгуудын нийт 30 гаруй чиглэлийн 2,500 гаруй сүү бэлтгэн нийлүүлэгч, малчид фермерүүдээс жилийн 4 улирал тасралтгүй сүүгээ татан авч байна.



20
25

"СҮҮ"ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

► КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сүү ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хувьд 8 ердийн гишүүн, 4 хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



Д.ГАНБААТАР
ТУЗ-ийн дарга



Д.ЦЭРЭНЖИГМЭД
ТУЗ-ийн гишүүн



Д.ЖАМБЯН
ТУЗ-ийн гишүүн



Д.УЯНГАЛАНХУА
ТУЗ-ийн гишүүн



Б.ТҮВШИНТӨГС
ТУЗ-ийн гишүүн



Д.ТУНГАЛАГ
ТУЗ-ийн гишүүн



С.СҮХБОЛД
ТУЗ-ийн гишүүн



Б.ГАНТУЛГА
ТУЗ-ийн гишүүн



Б.БАТЗОРИГ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Г.БАЯР
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Н.ЦЭРЭНДОРЖ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Д.ДАВААНИАМ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн

20
25

"СҮҮ" ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН


► КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



№ Овог нэр	Албан тушаал	Ажиллах албан тушаал
ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО		
1. Д.Давааням	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. Д.Цэрэнжигмэд	ТУЗ-ийн гишүүн	Хорооны гишүүн
3. Г.Баяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн
АУДИТЫН ХОРОО		
1. Н.Цэрэндорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. Д.Тунгалаг	ТУЗ-ийн гишүүн	Хорооны гишүүн
3. Г.Баяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, КОМПЛАЙНСЫН ХОРОО		
1. Н.Цэрэндорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. С.Сүхболд	ТУЗ-ийн гишүүн	Хорооны гишүүн
3. Д.Давааням	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО		
1. Б.Батзориг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. Д.Ганбаатар	ТУЗ-ийн дарга	Хорооны гишүүн
3. Н.Цэрэндорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн

УДИРДЛАГЫН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Сүү ХК нь Гүйцэтгэх захирал, Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, Маркетинг, борлуулалт хариуцсан дэд захирал, Санхүү хариуцсан дэд захирал, Салбар үйлдвэр хариуцсан дэд захирал, Агро ферм хариуцсан дэд захирал болон 10 албаны дарга гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



Гүйцэтгэх захирал
Б.Гантулга



Үйлдвэрлэл хариуцсан
дэд захирал Д.Бямбажав



Маркетинг, борлуулалт
хариуцсан дэд захирал
Г.Пэлжидмаа



Санхүү хариуцсан
дэд захирал Ц.Баярсайхан



Салбар үйлдвэр хариуцсан дэд
захирал Б.Алтанхишиг



Агро ферм хариуцсан дэд
захирал Б.Ганзориг



Сүү худалдан авалтын
албаны дарга
Б.Амарбаясгалан



Чанар, Лабораторийн
албаны дарга
Ц.Батгэрэл



Худалдан авалт,
Хангамжийн
албаны дарга
Б.Ананд



Борлуулалтын
албаны Улаанбаатар хот
хариуцсан дарга
П.Эрдэнэбаатар



Захиргаа, Хуулийн албаны
дарга
Б.Ариунболд



Борлуулалтын
албаны хөдөө орон нутаг
хариуцсан дарга
Б.Сүхбат



Тээвэр, ложистикийн
албаны дарга
Ц.Баасандорж



Технологийн
албаны дарга
С.Оюунбилэг

20
25

"СҮҮ"ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

► КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амгаланг эрэн мэндчилье.

Сүүлийн жилүүдэд манай компанийн зүгээс шийдмэг томоохон хөрөнгө оруулалтуудыг хийж, 2025 оны эхний хагаст тоног төхөөрөмжүүдээ ашиглалтад бүрэн оруулж, үндсэн бүтээгдэхүүний чанарт үсрэнгүй дэвшлийг авчирч, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулснаас гадна Италийн SACCO SYSTEM компанийн боловсруулсан SYN-BIO 100 пробиотик агуулсан Provita йогуртыг шинээр зах зээлд амжилттай нэвтрүүлэн, хэрэглэгчийн таашаалыг хүртсээр байна.

Үүгээр зогсохгүй БНСУ-ын Lavelee брэндийн 4 төрлийн зайрмагийг хэрэглэгч, олон нийтэд хүргэн, амьд жимс, амт чанарын дээдийг түгээн ажиллаж байна. Энэхүү онцлох ажлууд болоод сүүн гэр бүлийн нөр их зүтгэлийн үр дүнд нийт цэвэр борлуулалтын орлого өнгөрөгч оны мөн үеэс 19.8% өссөн гүйцэтгэлтэйгээр эхний хагас жилээ үдэж байна. Манай хамт олон өнгөрөгч хагас жилд тогтвортой хөгжлийн зорилго дор сүү бэлтгэн нийлүүлэгч малчид, фермерүүд болон хоршоод руу чиглэсэн олон үйл ажиллагаа явуулсан нь үр дүнгээ өгсөөр байна. Тухайлбал, 447 тонн эрдэнэ шишийн даршийг өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд тараалаа. Ингэснээр малчдыг дэмжих, эргээд чанартай сүү бэлтгүүлэн авах томоохон ажил хэмээн үзэж байна.

Түүнчлэн, 2025 оны 4 дүгээр сард хүүхэд багачуудын оюун ухаан, сэтгэн бодох чадварыг бага наснаас нь хөгжүүлэх, шатрын спортыг олон нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Сүү" Хувьцаат Компанийн нэрэмжит өсвөрийн шатарчдын "СҮҮ 365" тэмцээнийг 3 дахь удаагаа амжилттай зохион байгуулсан. Уг тэмцээн нь өргөн цар хүрээг хамарч 600 гаруй бяцхан тамирчид оюун ухаанаа уралдуулсан өгөөжтэй үйл ажиллагаа болсон тул Сүү ХК Монгол оюуныг хөгжүүлэх, дэмжих их үйлсэд өөрийн тууштай хувь нэмэр болгох үүднээс цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүгээр зогсохгүй бид нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд чиглэсэн сайн дурын болон урт хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан, хэрэгжүүлж байна. Бид бүхэн цаашид сүүний салбарын хөгжлийн төлөө илүү том алсын хараатайгаар олон чанартай сүүн болон эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдийг шинээр нэвтрүүлэхийн төлөө зорин ажиллах болно.

Гүйцэтгэх захирал:

Б.ГАНТУЛГА

20
25

"СҮҮ"ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

▶ КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ »

WWW.SUU.MN

ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР НИЙЛҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



PROVITA ЙОГУРТ

Итали Улсын Sacco системийн Synbio 100 ашигтай бактеритай амьд йогурт Provita нь 2025 оны гуравдугаар сараас эхлэн Монгол Улсын зах зээлд амжилттай байршиж, өдгөө хэрэглэгчийн талархлыг хүлээгээд байна. Өдөр бүр хэрэглэгчдийн гарт шинэжнээрээ очих энэхүү йогурт нь гэдэсний бичил орчныг дэмжих, дархлаа сайжруулах, нарийн тоосонцрын харшлын шинж тэмдгийг бууруулах, хоол боловсруулах системийг дэмжих зэрэг олон талын ач тустай бүтээгдэхүүн юм.



LAVELEE ЗАЙРМАГ

БНСУ-ын алдарт Lavelee брэндийн Eternal spring BAR, MANGO 30% BAR, Banana chocochip, Double ting зэрэг бүхэл жимс болон жимсний нухашны агууламж өндөртэй витамин, антиоксидант, эрүүл мэндийг дэмжих, калори багатай, пробиотикоор баялаг гэдгээрээ онцлог дөрвөн төрлийн зайрмагийг Сүү ХК Монгол Улсад албан ёсны эрхтэйгээр, хэрэглэгчдэд хүргэж байна. Уг бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн сэрүүцэх, эсвэл амттан идэх хүсэлд нь тусалж, эрүүл мэндэд ч анхаарах бүтээгдэхүүн юм.

2025

"СҮҮ" ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

► 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

БОРЛУУЛАЛТЫН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ӨСӨЛТ **↑19.8%**

20
25

"СҮҮ" ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

► 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ


2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН »

WWW.SUU.MN



ЦЭВЭР БОРЛУУЛАЛТ /тэрбум төгрөг/

2025 оны эхний хагас жилийн байдлаар Сүү ХК-ийн **цэвэр борлуулалтын орлого 115 тэрбум төгрөгт** хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулбал **▲19.8%**-ийн өсөлтийг үзүүлсэн байна.

20
25

"СҮҮ"ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН


КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/

2025 оны эхний хагас жилийн байдлаар Сүү ХК-ийн **Цэвэр ашиг** өмнөх оны мөн үетэй харьцуулахад **▼46.2%-аар буурч, 6.9 тэрбум төгрөгт** хүрлээ.

20
25

"СҮҮ" ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА


2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ



2025

2025 оны хагас жилийн байдлаар Сүү ХК-ийн **Нийт Хөрөнгийн өгөөж 4.1%** байна.

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ



2025

2025 оны хагас жилийн байдлаар Сүү ХК-ийн **Өөрийн Хөрөнгийн өгөөж 10.4%** байна.

20
25

"СҮҮ"ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН


КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

САНХҮҮГИЙН АУДИТЛАГДААГҮЙ ЕРӨНХИЙ ТОЙМ ТАЙЛАН

	Хэмжих нэгж /000,000/	1-р хагас 2024	1-р хагас 2025	Өсөлт %
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН				
Эргэлтийн хөрөнгийн дүн	Сая.төг	52,872	56,885	↑7.6%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	Сая.төг	78,997	110,160	↑39.4%
Нийт Хөрөнгө	Сая.төг	131,869	167,045	↑26.7%
Өр Төлбөр	Сая.төг	72,865	100,491	↑37.9%
Эздийн өмч	Сая.төг	59,004	66,554	↑12.8%
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	Сая.төг	131,869	167,045	↑26.7%
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН				
Борлуулалтын орлого (цэвэр)	Сая.төг	95,982	115,031	↑19.8%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	Сая.төг	65,609	81,256	↑23.8%
Нийт ашиг (алдагдал)	Сая.төг	30,372	33,775	↑11.2%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	Сая.төг	15,505	8,647	↓44.2%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	Сая.төг	12,813	6,891	↓46.2%

2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгө нь өмнөх оны мөн үеэс ▲26.7% өссөн энэхүү үзүүлэлт нь **компанийн өргөжин тэлэлттэй** байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /Тэрбум ₮/



Нийт гаргасан хувьцаа:

344,000,000

Тикер	MSE:SUU
Бирж	МХБ
Ангилал	I(19), ТОП20(16) индекс
Зах зээлийн үнэ /2024.06.30/	233.9 тэрбум
Нээлтийн ханш	642₮
Хаалтын ханш	679.99₮

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2025

"СҮҮ"ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН »

WWW.SUU.MN

ХАМТЫН АЖИЛЛАГАА



“Ухрийн зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалт”-ын хүрээнд Сүү ХК-ийн гишүүн хоршоодыг хамруулан Сүү ХК, Нутаг академи, Малын удмын сангийн үндэсний төв, Global Civic sharing хамтран 7 хоногийн вакумжуулсан сургалтыг 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа



20
25

"СҮҮ" ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

▶ 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХАМТЫН АЖИЛЛАГАА

447ТН ◀
Эрдэнэ шишийн
дарш

Сүү ХК-д сүү бэлтгэн нийлүүлдэг 2,500 гаруй малчин фермерүүдэд зориулж 2024-2025 оны өвлийн улиралд нийт 447 тн эрдэнэшишийн дарш тараан дэмжин ажиллав. Энэ нь дан ганц малчид, фермерүүдийг дэмжихээс гадна хэрэглэгчдийг шинэ, чанартай сүүгээр хангахад томоохон туслалцаа болох юм.



**20
25**

"СҮҮ" ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХАМТЫН АЖИЛЛАГАА



СҮҮ ХК БОЛОН ГССҮТ ХАМТРАН ХҮҮХДИЙГ АЮУЛ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛД АЖИЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ

Сүү хувьцаат компани нь "Эрүүл, чийрэг, монгол хүний төлөө" уриатайгаар хэрэгжүүлж буй SUU 365 хөтөлбөрийн хүрээнд Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв (ГССҮТ)-тэй хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд ГССҮТ-ийн эмч, мэргэжилтнүүд ЕБС-ийн 500 гаруй сурагчид зориулан "Бодит орчинд нь танилцах" нэртэй практик сургалтыг зохион байгуулах юм. Сургалтаар хүүхдүүдийг аюул осол, гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх талаар мэдлэг, дадлага олгоно.

Энэхүү санаачилга нь Монголын хүүхдүүдийг эрүүл, чийрэг, аюулгүй өсөж торних нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээний нэг бөгөөд цаашид хамрах хүрээгээ тэлж, олон нийтэд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

20
25

"СҮҮ"ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХАМТЫН АЖИЛЛАГАА

"ДЭЛХИЙН СҮҮНИЙ ӨДӨР" (WORLD MILK DAY)-ИЙГ ТОХИОЛДУУЛАН МОНГОЛ УЛСАД АНХ УДАА "MILK FESTIVAL-2025"-ЫГ ХХААХҮЯ, НҮБ-ЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА (FAO), ҮНДЭСНИЙ ТОМООХОН ҮЙЛДВЭРЛЭГЧИД БОЛОХ 5 КОМПАНИТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Түүнчлэн, уг өдрөөр Сүү ХК нь хамтран ажиллагч малчид, фермерүүдийнхээ бэлэг болгон хүргүүлсэн 10,000 литр сүүг "Дэлхийн сүүний өдөр", "Хүүхдийн баяр"-ыг тохиолдуулан "Milk Festival-2025"-д хүрэлцэн ирсэн мянга, мянган хүүхэд багачуудынхаа эрүүл мэнд, ирээдүйд зориулан амттай, мөн эрүүл бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж бэлэглэлээ.



20
25

"СҮҮ" ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХАМТЫН АЖИЛЛАГАА

АЧАА ТЭЭВРИЙН 10 АВТОМАШИНЫГ ХҮЛЭЭН АВЛАА

Сүү ХК нь олон улсын хүнсний тээврийн стандартад бүрэн нийцсэн, хөргүүртэй ган бүхээг бүхий 10 ширхэг ачаа тээврийн автомашиныг МСМ Группээс хүлээн авлаа. Эдгээр автомашинууд нь Сүү ХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэгч олонд чанар, стандартыг алдагдуулахгүйгээр аюулгүй, шинэхнээр хүргэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл дүүрэн байна.



20
25

"СҮҮ" ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

▶ 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Сүү ХК 500 гаруй хүүхэд, багачуудыг сүүн соёлыг таниулах аялалд хамрууллаа

Үндэсний ууган үйлдвэр Сүү ХК нийгмийн хариуцлагын хүрээнд тавдугаар сарын турш ерөнхий боловсролын 10 гаруй сургуулийн 500 гаруй хүүхэд, багачуудыг Сүү ХК-ийн үйлдвэртэй танилцах аялалд урин оролцууллаа.

Энэхүү үйл ажиллагаа нь зөвхөн үйлдвэрийн танилцуулга төдийгүй, хүүхэд залуусыг эрүүл хүнсний хэрэглээний зөв дадалд уриалсан, нээлттэй, боловсрол олгох сайн туршлага болж чадсан гэдэгт итгэл дүүрэн байна.



20
25

"Сүү"ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

▶ 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



"Сүү" ХК нь "Эрдмийн өргөө" сургууль болон "Хос бэрс агро ферм" -тэй хамтран ерөнхий боловсролын 3000 гаруй сурагчийг сүүний фермийн үйл ажиллагаатай танилцууллаа.

Сурагчдад мэргэжилийн чиг баримжаа олгох, хичээлийн цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд өндөр үр дүнтэй туршлага болсон хэмээн найдаж байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

БУРХАН БАГШИЙН ИХ ДҮЙЧИН ӨДӨР АРИУН ЦАГААН СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР БУЯН ХУРААХ ИХ ҮЙЛД ОРОЛЦЛОО

Бурхан багшийн их дүйчин өдөр Сүү ХК Чингисийн талбайд зохион байгуулагдсан "Buddha Festival"-д оролцож, ариун цагаан сүү, сүүн бүтээгдэхүүнээ хэрэглэгч, монгол түмэндээ өргөн барьж буян хураах их үйлд оролцлоо.



20
25

"СҮҮ" ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

СҮҮ 365 ӨСВӨРИЙН ШАТАРЧДЫН ТЭМЦЭЭН

Сүү ХК-ийн уламжлал болгон зохион байгуулдаг өсвөрийн шатарчдын тэмцээнийг "БИ ӨДӨР БҮР СҮҮ УУДАГ ОЮУНЛАГ ТАМИРЧИН" уриан дор Монгол Улсын зүүн хязгаарын Дорнод аймаг, хойд хязгаарын Хөвсгөл аймаг, өмнөд бүсийн Өмнөговь аймаг болон бусад аймаг, нийслэлээс 5-18 насны нийт 600 гаруй өсвөрийн шатарчныг хамруулсан нь онцлог байв.

Тэмцээнийг нийт 40 сая төгрөгийн шагналын сантайгаар зохион байгуулсан бөгөөд шатраар хичээллэдэг хүүхэд бүрд ижил тэгш оролцох боломжийг олгож, оюун ухаанаа хөгжүүлэн, авьяас чадвараа нээх, ирээдүйгээ итгэл төгс бүтээхэд нь бодитой хувь нэмэр орууллаа.



20
25

"СҮҮ" ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

▶ 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Спортыг дэмжигч Сүү ХК Вьетнам улсад зохион байгуулагдсан Азийн Үндэсний Цомын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон Монгол Улсын волейболын эмэгтэй шигшээ багийн ерөнхий ивээн тэтгэгчээр ажилласан.

Тус тэмцээнд Монголын Улсын волейболын эмэгтэй шигшээ баг амжилттай оролцож, дэлхийн чансаагаар 166 дугаарт бичигдэж байснаас 68-р байрт дэвшин, тэмцээнээ өндөрлүүлсэн.



2025

"СҮҮ"ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

▶ 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



Сүү ХК нь "Сүүн гэр бүл"-ийн шилдэг 8 ажилтанд сар шинийн босгон дээр орон сууцны урьдчилгаа олгон урамшууллаа. Компанийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд бид жил бүр уламжлал болгон шилдэг ажилтнууддаа дэмжлэг үзүүлдэг бөгөөд энэ жил 6 дахь жилдээ нийт 650,000,000 төгрөгийн дэмжлэгийг олголоо.

20
25

"СҮҮ" ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХЭРЭГЛЭГЧИЙН ИДЭВХЖҮҮЛЭЛТ

Сүү ХК-ийн үйлдвэрлэдэг таргаас дуртай төрлөө сонгон хэрэглэж, сая төгрөгийн эзэн болох "90 САЯТАН - ТАРГИЙН БАЯР" урамшуулалт хөтөлбөрийг гурван сарын хугацаанд хэрэгжүүлэв. Уг хөтөлбөр нь өдөр бүр нэг саятан тодрох бөгөөд нийт 90 сая төгрөгийн шагналын сантай юм.



2025

"СҮҮ" ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

► 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН
ҮЙЛ
АЖИЛЛАГАНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХАМТЫН ҮР ӨГӨӨЖ



- 13,000 Хувьцаа эзэмшигчид
- 4,200 Харилцагчид
- 2,500 Сүү бэлтгэн нийлүүлэгчид
- 763 Ажилтан



20
25

"СҮҮ" ХК-ийн
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

▶ 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ»

WWW.SUU.MN



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Сүү” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байдаг. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөл нь нийт 12 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааг байнгын, тогтвортой, мэргэжлийн удирдлагаар хангаж, Компанийн тухай хууль, Төрийн холбогдох эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон компанийн дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооноос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн дагуу ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болоод баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

20
25

“СҮҮ”ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

► КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

WWW.SUU.MN



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД



БАРИМТ БИЧИГ



**Та дээрхи заавраар
холбогдох мэдээллийг
авах боломжтой**

- Компанийн тогтвортой хөгжлийн бодлого
- Компанийн ногдол ашгийн бодлого
- Компанийн залгамж халааны бодлого
- Компанийн залгамж халааны бодлого
- Компанийн цалин урамшууллын бодлого
- Компанийн дотоод аудитын заавар
- Компанийн дотоод хяналтын заавар
- Компанийн эрсдлийн удирдлагын заавар
- Компанийн комплайнсын хяналтын заавар
- Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
- Компанийн эрх бүхий албан тушаалтны ёс зүйн дүрэм
- Компанийн мэдээллийн ил тод байдал тайлагналын журам
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зарчлийг зохицуулах журам
- ТУЗ-ийн оролцогч талын бодлого
- ТУЗ-ийн нэр дэвшүүлэх журам
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлага, комплайнсын хорооны үйл ажиллагааны журам

**Компанийн засаглалын
кодексийн холбогдох журмуудыг
эцэслэн батлав.**

**20
25**

"СҮҮ" ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

► КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

WWW.SUU.MN



Код: 135	Бүртгэлтэй бирж: Монголын Хөрөнгийн Бирж	Бүртгэгдсэн огноо: 1992 он	Бизнес: Хүнсний үйлдвэрлэл
Хувьцааны төрөл: Энгийн	Бүртгэлийн ангилал: I ангилал	ISIN : MN00APU00900	Хувьцааны симбол: SUU

Хувьцааны мэдээлэл

Ногдол ашигийн
мэдээлэл

Хувьцаа
эзэмшигчдийн бүтэц

Хувьцааны өгөөжийн
тооцоолол хийх

Хувьцаа худалдан
авах заавар

Товчин дээр дарж дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.



Та дараах заавраар дор дурдсан
мэдээллийг авах боломжтой

ХУВЬЦАА

НОГДОЛ АШИГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ХУВЬЦААНЫ ӨГӨӨЖИЙН ТООЦООЛОЛ

ХЭРХЭН ХУВЬЦАА ХУДАЛДАЖ АВАХ ВЭ?

20
25

"СҮҮ"ХК-ИЙН
ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БОРЛУУЛАЛТЫН
МЭДЭЭ

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

► КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА